



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/01/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас:  
[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Улиастай сум  
2024 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын

Дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: [bat-undraa@audit.gov.mn](mailto:bat-undraa@audit.gov.mn)

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: [boldbaatarkh@audit.gov.mn](mailto:boldbaatarkh@audit.gov.mn)

Ахлах аудитор: Ц.Оюунсүвд

Утас: 99076038

Цахим хаяг: [oyunsuvdts@audit.gov.mn](mailto:oyunsuvdts@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3-5
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	6-11
3. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11-20
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11-12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12-13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	13-20
4. Аудитын тайлан.....	20-23
4.1 Ерөнхий зүйл.....	20-21
4.2 Материаллаг байдал.....	21
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт .....	21-22
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	22-23
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	23-24
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	24
5. Аудитын илрүүлэлт .....	24-27
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	28-30

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчийн Хурал
НҮБ	Нэгдсэн Үндэсний байгууллага
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ


**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улнастай, Завхан аймаг  
Утас/Факс: 7046-36-12  
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

додд-04-30 № 489

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
Г.ӨНӨРБАЯР-Т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Завхан аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Завхан аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн сумдын Засаг дарга нарт сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлагуудыг хэрэгжүүлээгүй болон Засаг даргын нөөц хөрөнгийг үр ашиггүй, үрэлгэн зарцуулсан 279.6 сая төгрөгийн, хөрөнгө оруулалтын шинжтэй зардлыг санхүүжүүлсэн 131.3 сая төгрөгийн, албан ажлаасаа чөлөөлөгдөөгүй үргэлжлүүлэн ажиллаж байгаа Эрдэнэхайрхан сумын Засаг даргын орлогчид ээлжит сонгуулийн дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын дарга болон бүх шатны Засаг дарга нарт олгох нэг удаагийн тэтгэмжийг олгосон 4.8 сая төгрөгийн, хөрөнгө оруулалтын ажлын зураг төсвийн 87.8 сая төгрөгийн зардлыг тендер зарлаагүй олгосон, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, техник хяналтын зардлаас 97.8 сая төгрөгийг зориулалт бусаар үрэлгэн зарцуулсан зэрэг материаллаг зөрчлүүд байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 14 дүгээр зүйлийн 14.2.2-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох”, 14.2.3-т “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6-

01.09.2023

д "үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх", 12 дугаар зүйлийн 12.1.4-д "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1-д "Аймаг, сум, нийслэл, дүүргийн Хурлын дарга болон бүх шатны Засаг дарга ээлжит сонгуулийн дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бол тэдгээрт урьд нь эрхэлж байсан албан тушаалын зургаан сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно", Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д "албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй бол" гэж заасантай нийцэхгүй байна.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд аймаг үүсэн байгуулагдсаны 100 жилийн ой болж, арга хэмжээнд аймгийн Орон нутгийн хөгжлийн сан, Засаг даргын нөөц хөрөнгө, Биеийн тамир спортын улсын хороо, Соёл урлагийн газар зэрэг төсвийн эх үүсвэрээс 1,602.2 сая төгрөгийг зарцуулжээ.

#### **Аудитын гол асуудал**

Барьцаа хөрөнгийн дансанд 2018 онд үүссэн 41.5 сая төгрөгийн, Засаг даргын нөөц хөрөнгө дансанд 2016 онд үүссэн 2.6 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй, цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогын дансанд орон нутгийн хөрөнгө оруулалтаас 19.0 сая төгрөгийг шилжүүлсэн, мөнгөн төлбөрийн орлогоос 4.6 сая төгрөгийг хоол, бэлэг дурсгалын зардалд үр ашиггүй, үрэлгэн зарцуулсан, ингэхдээ нэр данс зөрүү ангиллаар ажил гүйлгээг хийж, орлого, зардлыг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй 37.5 сая төгрөгийн, цэргийн штабын бэлэн байдал, мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгоор худалдаж авсан тоног төхөөрөмжийг данс бүртгэлд тусгаж, эзэмшүүлээгүй 3.0 сая төгрөгийн зөрчлүүд байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 11,366.6 сая төгрөгийн зөрчил илэрч, 12 байгууллага хязгаарлалттай, 2 байгууллага сөрөг, 1 байгууллага татгалзсан дүгнэлт авсан байна.

Харьяа байгууллагуудын алдаа, зөрчлийг нэгтгэн дүгнэхэд сумдад эрх шилжүүлсэн болон ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй, хөрөнгө оруулалтын хүрээнд бий болсон үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүйтэй холбоотой 498.5 сая төгрөгийн зөрчил давтагдан гарсан байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс нэгтгэсэн санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		21,160,186.4	23,195,332.7
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	3а, 3б	13,869,800.2	14,862,591.6
33	<b>АВЛАГА</b>	5а, 5б, 6а, 6б	5,675,134.2	6,274,907.8
34	<b>УРЬДЧИЛГАА</b>	7а, 7б	3,142.4	2,729.7
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	8а, 8б, 8в	1,612,109.6	2,055,103.6
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		37,652,694.4	44,287,039.4
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	12а, 12б, 12в	37,652,694.4	44,287,039.4
39200	<b>Биет хөрөнгө</b>		34,882,835.0	41,203,019.5
39300	<b>Биет бус хөрөнгө</b>	13	2,769,859.4	3,084,020.0
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		58,812,880.8	67,482,372.2
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		1,797,979.5	2,181,689.1
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	15а, 15б	493,533.9	877,243.5
41300	<b>Өглөг</b>	17а, 17б	339,353.9	723,063.6
41400	<b>Урьдчилж орсон орлого</b>	18а, 18б	154,179.9	154,179.9
42	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		1,304,445.6	1,304,445.6
42200	<b>Урт хугацаат зээл</b>	20а, 20б	1,304,445.6	1,304,445.6
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		57,014,901.3	65,300,683.0
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>		57,014,901.3	65,300,683.0
51100	<b>Засгийн газрын оруулсан капитал</b>		17,809,156.2	17,805,346.6
51101	<b>Өмч /төрийн/ /ТӨҮГ/</b>		5,566,728.0	6,080,745.0
51105	<b>Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/</b>		202,588.0	202,588.0
51106	<b>Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/</b>		177,805.1	228,205.1
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>		26,948,039.5	34,675,712.7
51300	<b>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</b>		6,310,584.6	6,308,085.7
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		58,812,880.8	67,482,372.2

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>		123,748,404.0	81,863,877.5
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>		18,944,721.3	18,283,523.2
110	<b>Орлогын албан татвар</b>		13,293,409.0	13,512,377.6
1100	<b>Хувь хүний орлогын албан татвар</b>		9,245,248.3	13,105,607.0
1101	<b>Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт</b>		-838,869.3	-1,116,618.1
1102	<b>Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч</b>		5,685.8	0.0
1103	<b>ААН-ын орлогын албан татвар</b>		4,881,344.2	1,523,388.6
113	<b>Хөрөнгийн албан татвар</b>		1,651,046.8	2,242,392.5
118	<b>Бусад татвар, төлбөр, хураамж</b>		4,000,265.5	2,528,753.1
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	1а, 1б	34,952,563.3	52,786,947.3
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>		12,933,188.9	14,696,251.7
123	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>		22,019,374.4	38,090,695.6
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>		69,851,119.4	10,793,407.1

**Завхан аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит**

<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	2а, 2б	105,769,903.4	47,896,960.4
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		105,769,903.4	47,896,960.4
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		44,405,450.0	46,994,191.0
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		11,146,810.6	14,452,055.1
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		1,428,869.1	1,835,826.9
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		11,423,827.5	1,272,653.3
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		1,077,028.7	1,454,562.9
<b>2105</b>	<b>Нормативд зардал</b>		120,121.2	176,277.5
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		566,849.1	255,570.3
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>		206,654.0	378,408.3
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		4,886,541.7	5,924,858.6
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		13,548,748.1	21,243,978.1
<b>212</b>	<b>ТАТААС</b>		13,780.0	0.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		61,350,673.5	902,769.4
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>		17,978,500.5	33,966,917.1
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ</b>		131,137,183.1	26,042,563.2
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>		(113,158,682.5)	7,924,353.8

**2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	168,095,504.4	168,095,504.4
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,078,079.5	2,078,079.5
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	170,173,583.8	170,173,583.8
9	Тайлант үеийн үр дүн	(113,158,682.5)	(113,158,682.5)
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	57,014,901.3	57,014,901.3
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	57,014,901.3	57,014,901.3
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	361,427.9	361,427.9
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	57,376,329.2	57,376,329.2
19	Тайлант үеийн үр дүн	7,924,353.8	7,924,353.8
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	65,300,683.0	65,300,683.0

**2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	118,518,468.3	76,598,929.9
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	18,944,721.3	18,283,523.2
<b>110</b>	<b>Орлогын албан татвар</b>	13,293,409.0	13,512,377.6
<b>1100</b>	<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	9,245,248.3	13,105,607.0
<b>1101</b>	<b>Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт</b>	-838,869.3	-1,116,618.1
<b>1102</b>	<b>Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч</b>	5,685.8	0.0
<b>1103</b>	<b>ААН-ын орлогын албан татвар</b>	4,881,344.2	1,523,388.6
<b>113</b>	<b>Хөрөнгийн албан татвар</b>	1,651,046.8	2,242,392.5
<b>118</b>	<b>Бусад татвар, төлбөр, хураамж</b>	4,000,265.5	2,528,753.1
<b>1180</b>	<b>Бусад нийтлэг төлбөр, хураамж</b>	478,818.1	381,359.4
<b>1181</b>	<b>Газрын төлбөр</b>	999,478.2	1,019,190.8
<b>1182</b>	<b>Байгалийн нөөц ашигласны төлбөр</b>	2,519,431.2	1,126,244.5

Завхан аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит

1183	Бусад татвар	2,538.0	1,958.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	29,679,396.5	47,448,391.4
120	Нийтлэг татварын бус орлого	7,660,022.1	9,357,695.8
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	22,019,374.4	38,090,695.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	69,894,350.6	10,867,015.3
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	98,957,654.3	45,215,546.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	98,957,654.3	45,215,546.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	37,504,917.0	44,314,527.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	12,058,507.1	15,606,459.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,676,502.4	2,172,357.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,089,328.7	2,040,375.8
2104	Хангамж, бараа материалын зардал	1,531,828.3	1,878,003.8
2105	Нормативд зардал	120,294.6	175,738.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	508,588.4	268,396.6
2107	Томилолт, зочны зардал	196,635.2	373,595.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,499,481.7	3,701,871.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,823,750.7	18,097,728.4
212	ТАТААС	13,780.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61,438,957.3	901,019.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	19,560,814.0	31,383,383.0
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	6,792.9	3,065.6
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	22,543,645.8	28,578,682.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,543,645.8	28,578,682.0
2200	Дотоод эх үүсвэрээр	22,543,645.8	28,578,682.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-22,536,852.9	(28,575,616.4)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-1,997,696.3	(1,814,975.2)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,921,585.0	1,706,067.2
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	76,111.4	108,908.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-4,973,735.2	992,791.4
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	18,843,535.4	13,869,800.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,869,800.2	14,862,591.6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛ	67,698,899.3	60,749,946.7	6,948,952.6	89.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	39,616,764.6	37,422,302.6	2,194,462.0	94.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	38,131,361.9	36,522,556.9	1,608,805.0	95.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	14,805,930.2	14,381,664.0	424,266.2	97.1
210101	Үндсэн цалин	9,985,072.6	9,259,950.8	725,121.8	92.7
210102	Нэмэгдэл	4,366,674.7	4,090,011.9	276,662.8	93.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	209,186.0	200,148.7	9,037.3	95.7
210104	Урамшуулал	244,996.9	814,540.8	(569,543.9)	332.5
210105	Гэрээт ажлын хөлс	0.0	17,011.9	(17,011.9)	0.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,853,154.0	1,808,552.2	44,601.8	97.6
210201	Тэтгэврийн даатгал	1,261,123.2	1,231,372.7	29,750.5	97.6
210202	Тэтгэмжийн даатгал	148,007.0	144,922.3	3,084.7	97.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	118,406.7	116,258.1	2,148.6	98.2
210204	Ажилгүйдлийн даатгал	29,601.7	28,704.0	897.7	97.0
210205	Эрүүл мэндийн даатгал	296,015.4	287,295.1	8,720.3	97.1

**Завхан аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит**

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	11,854,796.9	11,463,180.1	391,616.8	96.7
210301	Гэрэл, цахилгаан	989,234.1	816,696.9	172,537.2	82.6
210302	Түлш, халаалт	10,458,870.7	10,265,709.5	193,161.2	98.2
210303	Цэвэр, бохир ус	400,692.1	367,773.7	32,918.4	91.8
210304	Байрны түрээс	6,000.0	13,000.0	(7,000.0)	216.7
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,097,324.1	1,029,993.2	67,330.9	93.9
210401	Бичиг хэрэг	134,666.9	138,275.9	-3,609.0	102.7
210402	Тээвэр, шатахуун	796,741.0	743,909.1	52,831.9	93.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	136,172.0	110,167.9	26,004.1	80.9
210404	Ном, хэвлэл	299.0	55.0	244.0	18.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	335.6	335.6	0.0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	29,109.6	37,249.6	(8,140.0)	128.0
<b>2105</b>	<b>Нормативд зардал</b>	175,738.5	175,738.5	0.0	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	175,203.5	175,203.5	0.0	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	535.0	535.0	0.0	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	712,725.8	656,225.4	56,500.4	92.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	100,457.1	77,385.9	23,071.2	77.0
210602	Тавилга	9,500.0	9,500.0	0.0	100.0
210604	Урсгал засвар	602,768.7	569,339.6	33,429.1	94.5
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	377,554.3	355,670.2	21,884.1	94.2
210702	Дотоод албан томилолт	377,554.3	355,670.2	21,884.1	94.2
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,336,251.4	3,171,807.3	164,444.1	95.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,248,874.2	3,112,593.3	136,280.9	95.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	16,413.6	1,788.3	14,625.3	10.9
210803	Даатгалын үйлчилгээ	20,094.6	15,820.2	4,274.4	78.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	7,833.2	4,948.0	2,885.2	63.2
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	2,803.1	1,112.2	1,690.9	39.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	24,049.0	21,720.3	2,328.7	90.3
210807	Газрын төлбөр	15,726.0	13,809.3	1,916.7	87.8
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	457.7	15.7	442.0	3.4
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3,917,886.7	3,479,726.1	438,160.6	88.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,781,119.4	3,348,368.0	432,751.4	88.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	136,767.3	131,358.1	5,409.2	96.0
<b>211</b>	<b>ХҮҮ</b>	568,710.9	0.0	568,710.9	0.0
<b>2111</b>	<b>Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр</b>	568,710.9	0.0	568,710.9	0.0
211101	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	568,710.9	0.0	568,710.9	0.0
<b>212</b>	<b>ТАТААС</b>	12,953.2	12,953.2	0.0	100.0
<b>2122</b>	<b>Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас</b>	12,953.2	12,953.2	0.0	100.0
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	12,953.2	12,953.2	0.0	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	903,738.6	886,792.4	16,946.2	98.1
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	903,738.6	886,792.4	16,946.2	98.1
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	115,600.0	115,579.9	20.1	100.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	18,000.0	15,498.3	2,501.8	86.1
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	101,923.9	94,347.7	7,576.2	92.6
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	553,940.2	547,458.1	6,482.1	98.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	114,274.5	113,908.5	366.0	99.7
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	25,048,362.8	21,700,927.7	3,347,435.1	86.6
223001	Бусад хөрөнгө	25,048,362.8	21,700,927.7	3,347,435.1	86.6

Завхан аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит

23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	3,033,771.9	1,626,716.4	1,407,055.5	53.6
230001	Эргэж төлөгдөх зээл	3,033,771.9	1,626,716.4	1,407,055.5	53.6
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	67,698,899.3	61,594,677.8	6,104,221.5	91.0
32	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	57,518,477.3	59,504,315.6	(1,985,838.3)	103.5
320001	Орон нутгийн төсвөөс	42,475,413.2	44,668,289.4	(2,192,876.2)	105.2
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	15,043,064.1	14,836,026.3	207,037.8	98.6
35	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	10,180,422.0	2,090,362.2	8,090,059.8	20.5
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	89,129.8	2,090,292.2	(2,001,162.4)	2345.2
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	70.0	(70.0)	0.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	10,091,292.2	0.0	10,091,292.2	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	3,244,952.2	(3,244,952.2)	0.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	4,089,753.3	(4,089,753.3)	0.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	5,048,683.3	6,154,538.4
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	4,682,910.6	6,054,438.4
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	4,121,647.3	5,981,214.0
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	533,162.8	84,673.7
210101	Үндсэн цалин	343,615.5	21,528.9
210102	Нэмэгдэл	37,923.0	3,267.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,044.5	3,359.0
210104	Урамшуулал	15,649.1	410.5
210105	Гэрээт ажлын хөлс	130,930.8	56,108.4
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	77,059.2	6,997.1
210201	Тэтгэврийн даатгал	67,287.4	6,916.2
210202	Тэтгэмжийн даатгал	4,157.3	20.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,420.7	16.2
210204	Ажилгүйдлийн даатгал	509.5	4.0
210205	Эрүүл мэндийн даатгал	3,684.2	40.4
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	48,321.4	66,525.7
210301	Гэрэл, цахилгаан	2,786.9	14,133.0
210302	Түлш, халаалт	38,189.4	50,513.8
210303	Цэвэр, бохир ус	7,345.1	1,878.9
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	87,744.1	122,182.9
210401	Бичиг хэрэг	12,541.5	7,076.5
210402	Тээвэр, шатахуун	45,364.5	100,573.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,959.8	2,846.6
210404	Ном, хэвлэл	13,060.0	0.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	270.1	275.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,548.1	11,411.1
<b>2105</b>	<b>Нормативд зардал</b>	5,475.0	0.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,475.0	0.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	14,342.4	33,400.6
210604	Урсгал засвар	14,342.4	33,400.6
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	18,683.8	20,485.3
210702	Дотоод албан томилолт	18,683.8	20,485.3

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	555,690.5	459,437.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	553,876.8	454,132.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	390.0	794.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,126.0	1,117.5
210807	Газрын төлбөр	213.4	2,900.5
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	84.3	492.2
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,781,168.1	5,187,511.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,778,180.8	5,186,881.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,987.3	630.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	561,263.3	73,224.4
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	70,753.4	14,227.4
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	500.0	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	70,253.4	14,227.4
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	490,509.9	58,997.0
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	63,251.3	0.0
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	427,258.7	58,997.0
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	365,772.6	100,099.9
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	365,772.6	100,099.9
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	365,772.6	100,099.9
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	5,188,273.2	5,808,456.2
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	5,188,273.2	5,808,456.2
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000.0	0.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,691,481.6	267,435.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,486,791.6	5,541,021.2
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	139,589.9	(346,082.1)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	818,302.7	957,892.6
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	957,892.6	611,810.5

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Аймгийн Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах, хэрэгжүүлэх, чиг үүрэг бүхий Засгийн газрын харьяа байгууллага юм.

**Эрхэм зорилго:** Иргэдийн оролцоонд тулгуурласан ил тод, хариуцлагатай, чадварлаг, үр дүнг эрхэмлэсэн төрийн албыг төлөвшүүлж, аймгийнхаа хөгжил, дэвшлийг оновчтой бодлого, зохицуулалтаар хангахад оршино.

“Эдийн засаг хүний нөөцийг үр бүтээмжтэй ашиглан, иргэдийн ажиллаж амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлж, тогтвортой ногоон хөгжлийг дэмжсэн аймаг болох” зорилтын хүрээнд хөгжлийн тулгуур чиглэлийг:

1. Аймгийн эдийн засгийн нөөцөд тулгуурласан хөгжил
2. Аймгийн нийгмийн үйлчилгээ ба хүний хөгжил
3. Ногоон хөгжилд суурилсан орон нутгийн хөгжил гэж тодорхойлсон байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны 2022 оны 57 дугаар тогтоолоор аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөг баталж, 5 зорилтын хүрээнд 188 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- Хүний хөгжлийн бодлогын хүрээнд 35 арга хэмжээ
- Эдийн засгийн хөгжлийн бодлогын хүрээнд 37 арга хэмжээ
- Засаглалын бодлогын хүрээнд 20 арга хэмжээ
- Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд 14 арга хэмжээ
- Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын хүрээнд 82 арга хэмжээ тус тус байна.

Харин аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны 2023 оны 69, 80 дугаар тогтоолоор аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөг тодотгож, 77 арга хэмжээг нэмж өөрчилсөн байна.

Аймгийн хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны 2023 оны 91 дүгээр тогтоолоор 265 арга хэмжээний хүрээнд 90.5 хувийн биелэлттэй буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэжээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Аймгийн Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль зэрэг хуулиудыг голлон мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжтой холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 63 төсөвт байгууллага, сан, төсөл хөтөлбөрүүдэд санхүүгийн хяналт шалгалт хийж, 184.6 сая төгрөгийн, 15 нэгжид дотоод аудит хийж 59.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.

Авлигатай тэмцэх газар, Цагдаа, иргэн, байгууллагын хүсэлт, үүрэг чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус шалгалтаар 4 нэгж байгууллагад хяналт шалгалт хийж дүгнэлт, танилцуулга хүргүүлжээ.

2023 онд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын төлөвлөгөө боловсруулан, байгууллагуудыг албаны улсын /ахлах/ байцаагч нарт хариуцуулан, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд шалгуур үзүүлэлтэд нэмж, ажил дүгнэх үзүүлэлт болгосон байна. Төрийн 199 байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдалд 4 удаа аудит хийж, ЗДТГ-ын цахим хуудсаар мэдээлж ажилласан байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагаанд мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд төрийн сангийн үйл ажиллагааны журмын хүрээнд бүртгэл хөтлөлтийг гүйцэтгэж байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн Засаг дарга нь 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаа Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,669.5 сая төгрөгөөр буюу 14.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/	
			Өөрчлөлт	Эзлэх хувь
Б	1	2	3=2-1	
Мөнгөн хөрөнгө	13,869.8	14,862.6	992.8	11.5%
Авлага	5,675.1	6,274.9	599.8	6.9%
Урьдчилгаа	3.1	2.7	0.4	0.005%
Бараа материал	1,612.1	2,055.1	443.0	5.1%
Үндсэн хөрөнгө	37,652.7	44,287.0	6,634.3	76.5%
<b>Нийт хөрөнгө</b>	<b>58,812.9</b>	<b>67,482.4</b>	<b>8,669.5</b>	<b>100%</b>
Өр төлбөр	1,798.0	2,181.7	383.7	4.4%
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	57,014.9	65,300.7	8,285.8	95.6%
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>58,812.9</b>	<b>67,482.4</b>	<b>8,669.5</b>	<b>100%</b>

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо зэрэг данснуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 14,862.5 сая төгрөг болж, өмнөх оноос 992.8 сая төгрөгөөр өссөн байна. Нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 14,778.0 сая төгрөг буюу 99.4 хувь нь касс болон төрийн сангийн харилцах дансанд, 84.6 сая төгрөг буюу 0.6 хувь нь арилжааны банканд байршиж байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өсөлт (+), Бууралт (-)	
Кассад байгаа бэлэн мөнгө	4.8	0.06	(4.7)	
<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>13,865.0</b>	<b>14,862.5</b>	997.5	
Төрийн сангийн харилцах	12,862.3	14,166.1	1303.8	
Арилжааны банк дахь харилцах	44.8	84.6	39.8	
Нэмэлт санхүүжилт харилцах	957.9	611.8	(346.1)	
<b>Дүн</b>	<b>13,869.8</b>	<b>14,862.6</b>	<b>992.8</b>	
<b>Байгууллагын төрлөөр</b>				
Төсөвт байгууллага	3,254.9	4,102.2	847.3	
Төсөл сан	2,283.0	2,523.8	240.8	
Төрийн сан	8,289.7	8,154.7	(135.0)	
ОНӨААН	42.2	81.8	39.6	
<b>Дүн</b>	<b>13,869.8</b>	<b>14,862.5</b>	<b>992.8</b>	

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд тайлант онд хийгдэж дуусаагүй хөрөнгө оруулалтуудын үлдэгдэл санхүүжилтийг

барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан болон Дөрвөлжин, Улиастай сумдын татварын орлого давж биелсэн нь гол нөлөөг үзүүлжээ.

Нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 27.6 хувийг төсөвт байгууллага, 17.0 хувийг төсөл сан, 54.9 хувийг төрийн сан, 0.5 хувийг орон нутгийн өмчит хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгө тус тус эзэлж байна.

**Аудитын илрүүлэлт:** ТЕЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар Засаг даргын нөөц хөрөнгөөс 279.6 сая төгрөгийг Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж, арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй, үрэлгэн зарцуулсан, 131.3 сая төгрөгөөр хөрөнгө оруулалтын шинжтэй зардлыг санхүүжүүлсэн, цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлого, зардлыг нягтлан бодох бүртгэлд тусгалгүй, нэр данс зөрүү гэсэн ангиллаар ажил гүйлгээг хийсэн, цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогын дансанд орон нутгийн хөрөнгө оруулалтаас 19.0 сая төгрөгийг төвлөрүүлэн, нэр данс зөрүү гэсэн ангиллаар зарцуулж, нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогоос 4.6 сая төгрөгийг үр ашиггүй, үрэлгэн зарцуулсан зөрчилд зөвлөмж өгөхөөр, техник хяналтын зардлаас 97.8 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулж, хяналт тавиагүй зөрчилд албан шаардлага өгөхөөр, мөн албан ажлаасаа чөлөөлөгдөөгүй Эрдэнэхайрхан сумын Засаг даргын орлогчид ээлжит сонгуулийн дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын дарга болон бүх шатны Засаг дарга нарт олгох нэг удаагийн тэтгэмжийг олгосон 4.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ. Харьяа байгууллагуудын санхүүгийн аудитаар малчдад хөнгөлөлттэй олгосон өвс, тэжээл борлуулсны орлогыг хувь хүний дансанд төвлөрүүлж, бэлэн мөнгөний тайлан гаргаагүй, зарцуулалтын тайлан тооцоо хийж хяналт тавьдаггүй хувь хүний дансаар мөнгө дамжуулан зарцуулж, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй зэрэг зөрчил гарсан байна.

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 6,274.9 сая төгрөг болж, өмнөх оноос 599.8 сая төгрөгөөр өссөн байна. Нийт авлагын үлдэгдлийн 92.9 хувийг төсөвт байгууллага, 0.7 хувийг төсөл сан, 2.9 хувийг төрийн сан, 3.5 хувийг орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлага тус тус эзэлж байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбоотой авлага	5.8	7.2	1.4
Төлбөртэй үйлчилгээний авлага	100.1	179.5	79.4
Данс авлага /ТӨҮГ/	83.6	196.4	112.8
Татвар НДШ авлага /ТӨҮГ/	0.7	0.7	0
Байгууллагаас авах авлага	282.5	612.0	329.5
Хувь хүмүүсээс авах авлага	5,202.4	5,279.1	76.7
<b>Дүн</b>	<b>5,675.1</b>	<b>6,274.9</b>	<b>599.8</b>
<b>Байгууллагын төрлөөр</b>			
Төсөвт байгууллага	5,422.7	5,833.1	410.4
Төсөл сан	41.5	41.5	0.0
Төрийн сан	100.0	179.4	79.4
ОНӨААН	111.0	220.9	109.9
<b>Дүн</b>	<b>5,675.1</b>	<b>6,274.9</b>	<b>599.8</b>

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэл өмнөх оноос өссөн нь төсөвт байгууллагуудын авлага 410.4 сая төгрөгөөр, ОНӨААН-үүдийн авлага 109.9 сая төгрөгөөр нэмэгдсэн болон "Амь-Ус" ХХК орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн 1,304.4 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөрөөс тайлант онд 79.4 сая төгрөгийг орон нутгаас барагдуулж, тус аж ахуйн нэгжээс авах авлага үүссэн зэрэгтэй холбоотой байна.

**Аудитын илрүүлэлт:** ТЕЗ-ийн аудитаар барьцаа хөрөнгийн дансанд 2018 онд үүссэн 41.5 сая төгрөгийн, аймгийн Засаг дарга дансанд 2016 онд үүссэн 2.6 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй зөрчилд зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ. Харьяа байгууллагуудын хүрээнд Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй, зээлийн хугацаа хэтэрсэн иргэдийн шүүхийн байгууллагад шилжүүлээгүй, шүүхийн шийдвэрийн хугацаа дууссан байхад шийдвэр гүйцэтгэх газарт хүргүүлэн барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

### 3.4.3 Урьдчилгаа

Урьдчилж гаргасан зардал дансны үлдэгдэл 2.7 сая төгрөг болж 0.4 сая төгрөгөөр буурсан байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	3.1	2.7	0.4
<b>Дүн</b>	<b>3.1</b>	<b>2.7</b>	<b>0.4</b>

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.4.4 Бараа материал

Бараа материал дансны эцсийн үлдэгдэл 2,055.1 сая төгрөг болж, өмнөх оноос 443.0 сая төгрөгөөр өссөн байна. Нийт бараа материалын үлдэгдлийн 83.8 хувийг төсөвт байгууллага, 16.2 хувийг орон нутгийн өмчит хуулийн этгээдийн бараа материал тус тус эзэлж байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Түүхий эд материал</b>	<b>97.3</b>	<b>196.2</b>	<b>98.9</b>
Тусгай зориулалттай материал	95.3	194.2	98.9
Эм боох материал	2.0	2.0	0.0
Бэлэн бүтээгдэхүүн	0.9	0.9	0.0
<b>Хангамжийн материал</b>	<b>1,419.1</b>	<b>1,761.7</b>	<b>342.6</b>
Бичиг хэргийн материал	55.5	62.6	7.1
Аж ахуйн материал	802.6	899.8	97.2
Сэлбэг хэрэгсэл	27.7	43.7	16
Түлш, шатах тослох материал	23.0	86.6	63.6
Барилгын засварын материал	23.7	30.1	6.4
Хүнсний материал	0	0	0
Бусад хангамжийн материал	486.7	638.8	152.1
<b>Мал амьтад</b>	<b>98.7</b>	<b>96.3</b>	<b>(2.4)</b>
<b>Дүн</b>	<b>1,612.1</b>	<b>2,055.1</b>	<b>443.0</b>
<b>Байгууллагын төрлөөр</b>			
Төсөвт байгууллага	1,313.6	1,722.4	408.8
ОНӨААН	298.5	332.7	34.2
<b>Дүн</b>	<b>1,612.1</b>	<b>2,055.1</b>	<b>443.0</b>

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал 443.0 сая төгрөгөөр өссөн нь түүхий эд материал 98.9 сая төгрөгөөр, хангамжийн материал 342.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь гол нөлөөг үзүүлж байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 2,961.4 сая төгрөгийн бараа материал худалдан авч, хандив тусламжаар 59.8 сая төгрөгийн, хөрөнгө оруулалтаар 322.7 сая төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, балансаас баланст 20.5 сая төгрөгийн материал шилжүүлэн авч, нийт 3,364.4 сая төгрөгөөр нэмэгдэж, 2,822.7 сая төгрөгийн хөрөнгийг үйл ажиллагаандаа зарцуулан, 1.5 сая төгрөгийн бараа материалыг балансаас баланст шилжүүлж, 97.3 сая төгрөгийн бараа материалыг акталж, нийт 2,921.4 сая төгрөгөөр хасагдсан байна.

**Аудитын илрүүлэлт:** ТЕЗ-ийн аудитаар цэргийн штабын бэлэн байдал, мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгоор худалдаж авсан 3.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, бараа материал данс бүртгэлд тусгаж, эзэмшүүлээгүй зөрчил илэрсэнд зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ. Харьяа байгууллагуудын хүрээнд худалдан авсан бараа материалыг тодруулга тайлангаар дамжуулан бүртгэдэггүй, шууд зардлаар тайлагнасан, бараа материалыг зөв ангилж бүртгэдэггүй, хөрөнгө оруулалтаар ирсэн бараа материалыг данс бүртгэлд тусгаагүй орхигдуулсан, тооллогыг бодитой хийдэггүй, ашиглалтгүй, ашиглалтын шаардлага хангахгүй материалыг акталж устгах ажил хийгдээгүй зэрэг алдаа, зөрчлүүд илэрсэн байна.

### 3.4.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгөтэй холбоотой бүртгэл байхгүй байна.

### 3.4.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 44,287.0 сая төгрөг болж, өмнөх оноос 6,634.3 сая төгрөгөөр өссөн байна. Нийт үндсэн хөрөнгийн үлдэгдлийн 82.9 хувийг төсөвт байгууллага, 17.1 хувийг орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө тус тус эзэлж байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>34,882.8</b>	<b>41,203.0</b>	<b>6,320.2</b>
Барилга, байгууламж, орон сууц	30,526.2	33,557.3	3,031.1
Авто-тээврийн хэрэгсэл	6,247.1	7,995.9	1,748.8
Машин тоног төхөөрөмж(компьютер)	10,250.7	12,307.2	2,056.5
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,779.8	1,795.9	16.1
Зам гүүрний байгууламж	9.2	34.2	25.0
Түүх соёл, музейн дурсгалт зүйл	3.7	3.7	0.0
Бусад үндсэн хөрөнгө	5,762.1	7,733.8	1,971.7
Ном	23.7	28.7	5.0
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>2,769.9</b>	<b>3,084.0</b>	<b>314.1</b>
Программ хангамж	118.7	175.0	56.3
Бусад биет бус хөрөнгө	2,721.9	2,997.1	275.2
<b>Дүн</b>	<b>37,652.7</b>	<b>44,287.0</b>	<b>6,634.3</b>
<b>Байгууллагын төрлөөр</b>			
Төсөвт байгууллага	30,166.3	36,704.4	6,538.1
Төсөл сан	-	-	0.0
Төрийн сан	-	-	0.0
ОНӨААН	7,486.4	7,582.6	96.2
<b>Дүн</b>	<b>37,652.7</b>	<b>44,287.0</b>	<b>6,634.3</b>

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны өөрчлөлт нь төсвийн хөрөнгөөр 1,068.1 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан, улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 8,094.9 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгасан, 745.2 сая төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авсан, эрх бүхий байгууллагын шийдвэрээр 38.0 сая төгрөгийн хөрөнгө худалдсан, 423.1 сая төгрөгийн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассан, балансаас баланст 136.2 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн, мөн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ч цаашид ашиглах боломжтой хөрөнгүүдэд үнэ тогтоож, дахин үнэлгээний нэмэгдэл 118.1 сая төгрөгөөр нэмэгдэж, дахин үнэлгээний хорогдол 108.3 сая төгрөгөөр хасагдсан зэрэгтэй холбоотой байна.

**Аудитын илрүүлэлт:** ТЕЗ-ийн аудитаар улс, орон нутгийн хөрөнгө оруулалт, аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж байгаа төсөл арга хэмжээ, эрх шилжсэн хөрөнгө оруулалтад тавих хяналт хангалтгүй 498.5 сая төгрөгийн болон Хөрөнгө оруулалтын хүрээнд бий болсон үндсэн хөрөнгийн талаарх мэдээллийг Орон нутгийн өмчийн газарт мэдээлж хамтран ажилладаггүй, хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг данс бүртгэлд тусгадаггүй зөрчил жил бүр давтагдан гарч байгаад албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ. Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар тайлант онд худалдаж авсан болон улс, орон нутгийн хөрөнгө оруулалт, аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгө оруулалтыг данс бүртгэлд тусгаагүй, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлуудыг гэрээний хугацаанд бүрэн хийгдээгүй, урьдчилгаа олгосон ч ажил эхлээгүй, гэрээг сунгаж байгуулаагүй, эрх бүхий байгууллагын шийдвэргүй хөрөнгө бэлтгэсэн, үлдэх өртөггүй хөрөнгийн бүртгэлийг цэгцлэх, дахин үнэлгээ хийх шалгуур хангасан хөрөнгөнд үнэлгээ хийж бүртгэлд тусгах болон цаашид ашиглах боломжгүй хөрөнгүүдийг холбогдох газрын зөвшөөрлийн дагуу данснаас хасах арга хэмжээ авч ажиллаагүй, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй барилга байгууламжуудын газрыг үнэлж данс бүртгэлд тусгаагүй зэрэг алдаа, зөрчлүүд илэрсэн байна. Харьяа байгууллагуудад илэрсэн дээрх зөрчлүүдтэй холбогдуулан аймгийн Орон нутгийн өмчийн газарт зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Орон нутгийн хөрөнгө оруулалт болон аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн төсөл арга хэмжээг хүлээн авах комисст аймгийн Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтнүүдээс оруулж, бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлэх боломжоор хангаж ажиллах шаардлагатай байна.

### 3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 2,181.7 сая төгрөг болж, өмнөх оноос 383.7 сая төгрөгөөр өссөн байна. Нийт өр төлбөрийн үлдэгдлийн 16.9 хувийг төсөвт байгууллага, 83.1 хувийг орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө тус тус эзэлж байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>493.5</b>	<b>877.2</b>	<b>383.7</b>
Ажилчидтай холбогдсон өглөг	24.0	28.3	4.3
Бараа үйлчилгээний зардлын өглөг	28.9	57.6	28.7
Хувь хүмүүст төлөх өглөг	4.3	7.3	3
Байгууллагад төлөх өглөг	95.4	297.7	202.3
Татварын өглөг /ТӨҮГ/	69.7	190.9	121.2
НДШ өглөг /ТӨҮГ/	24.5	15.9	-8.6
Данс өглөг /ТӨҮГ/	92.6	125.4	32.8
<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>154.2</b>	<b>154.2</b>	<b>0.0</b>
Бусад урьдчилж орсон орлого	154.2	154.2	0.0
<b>Урт хугацаат өр төлбөр</b>	<b>1,304.4</b>	<b>1,304.4</b>	<b>0.0</b>
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	1,304.4	1,304.4	0.0
<b>Дүн</b>	<b>1,798.0</b>	<b>2,181.7</b>	<b>383.7</b>
<b>Байгууллагын төрлөөр</b>			
Төсөвт байгууллага	138.0	368.0	230.0
Төсөл сан	-	-	0.0
Төрийн сан	-	-	0.0
ОНӨААН	1,660.0	1,813.7	153.7
<b>Дүн</b>	<b>1,798.0</b>	<b>2,181.7</b>	<b>383.7</b>

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт өр төлбөр өссөн нь төсөвт байгууллагын өр төлбөр 230.0 сая төгрөгөөр, орон нутгийн өмчит аж ахуй нэгжийн өр төлбөр 153.7 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Төсөвт байгууллагуудын өр төлбөр өссөн нь Улиастай сумын Хот тохижилт үйлчилгээний алба ажлын байрны барилга худалдан авч, тайлант онд 200.0 сая төгрөгийг төлж, 200.0 сая төгрөгийг дараа онд төлөхөөр өглөг үүсгэсэн, Эрдэнэхайрхан сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлын санхүүжилтийг дутуу олгож, өглөг үүсгэсэн нь гол нөлөө үзүүлж байна.

**Аудитын илрүүлэлт:** ТЕЗ-ийн аудитаар өр төлбөртэй холбоотой зөрчил илрээгүй байна. “Амь-Ус” ХХК ОНӨААН-ийн 1,304.4 сая төгрөгийн урт хугацааны өр төлбөрийг орон нутгийн төсвөөс төлөхөөр 568.1 сая төгрөгийг төлөвлөсөн боловч тайлант онд тус өглөгийг төлөөгүй байна. Харин харьяа байгууллагуудын хүрээнд харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн актаар баталгаажсан өглөгийг данс бүртгэлд тусгаагүй, өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулдаггүй, санхүүгийн тайланд өглөг тусгаагдаагүй байхад өмнөх оны баримтаар зарцуулалт хийсэн зэрэг алдаа, зөрчлүүд байна.

### 3.4.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 65,300.7 сая төгрөг болж, өмнөх оноос 8,285.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	17,809.2	17,805.4	(3.8)
Өмч /ТӨҮГ/	5,566.7	6,080.7	514.0
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	202.6	202.6	0.0
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	177.8	228.2	50.4
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>26,948.0</b>	<b>34,675.7</b>	<b>7,727.7</b>
Өмнөх үеийн үр дүн	140,106.7	26,751.4	(113,355.3)
Тайлант үеийн үр дүн	(113,158.7)	7,924.4	121,083.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,310.6	6,308.1	(2.5)
<b>Дүн</b>	<b>57,014.9</b>	<b>65,300.7</b>	<b>8,285.8</b>

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 8,285.8 сая төгрөгөөр өссөн нь ОНӨААН-ийн өмч нэмэгдсэн, дахин үнэлсэн хөрөнгө акталснаас хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү буурсан болон тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 58 дугаар тогтоолоор аймгийн 2023 оны төсвийн жилд зарцуулах төсвийн суурь зарлагын хэмжээг 39,377.5 сая төгрөгөөр, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зардлыг 8,052.5 сая төгрөгөөр, аймгийн ОНХС-аас сумдад олгох орлогын шилжүүлгийг 6,274.0 сая төгрөгөөр баталж, санхүүжүүлэх эх үүсвэрийг татварын болон татварын бус орлого 6,003.3 сая төгрөг, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 17,716.3 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 11,932.6 сая төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 89.1 сая төгрөг, сумдын төсвийн аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 2,986.2 сая төгрөгөөр, урьд оны үлдэгдэл 649.9 сая төгрөгөөр баталсан байна.

Сумдын ИТХ-ын тогтоолоор 2023 онд зарцуулах зардлын хэмжээг 55,994.5 сая төгрөгөөр баталж, аймгийн ИТХ-ын хуралдаанаар баталсан суурь зарлагыг 16,617.0 сая

төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан бөгөөд сумын урьд оны үлдэгдэл болон сумын төсвийн орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

2023 оны төсвийн тодотголоор Аймгийн ИТХ-ын хуралдааны 2023 оны 81 дугаар тогтоол, сумдын ИТХ-ын тогтоолоор нийт зарлагыг 67,698.9 сая төгрөгөөр тодотгон, 11,704.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталжээ. Энэхүү зардлыг урьд оны үлдэгдэл болон татварын нэмэлт даалгаврын орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 21 арга хэмжээг санхүүжүүлэхээр гүйцэтгэлээр улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс 23,254.7 сая төгрөг, ОНХС-д олгох орлогын шилжүүлгээс 14,836.0 сая төгрөг, татварын болон татварын бус орлогоос 21,413.6 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 2,090.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Хүснэгт 1. Орлогын гүйцэтгэл

/сая төгрөгөөр/					
д/д	Санхүүгийн эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	23,254.5	23,254.7	(0.2)	100%
2	ОНХС-аас олгох орлогын шилжүүлэг	15,043.1	14,836.0	207.1	98.6%
3	Татварын болон татварын бус орлого	19,220.9	21,413.6	0.0	100%
4	Урьд оны үлдэгдэл	10,091.3	2,192.7	7,898.6	21.7%
5	Үндсэн үйл ажиллагааны орлого	89.1	2,090.3	2,001.2	2346%
<b>ДҮН</b>		<b>67,698.9</b>	<b>61,594.6</b>	<b>6,104.3</b>	<b>91%</b>

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 60,749.9 сая төгрөг буюу 89.7 хувьтай байгаа нь урсгал үйл ажиллагааны зардлын төсвийг 2,194.5 сая төгрөг, хөрөнгийн зардлыг 3,347.4 сая төгрөгөөр дутуу зарцуулсан, эргэн төлөгдөх зээлийг төлөвлөсөн хэмжээнээс 1,407.1 сая төгрөгөөр дутуу олгосон зэрэгтэй холбоотой байна.

ТЕЗ нь 2023 оны батлагдсан төсвийг 6,949.0 сая төгрөг буюу 10.3 хувиар хэмнэсэн нь орон нутгийн тусгай сангуудын төлөвлөлт бодитой бус, Хоршоог хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт гэрээний хугацаанд төлөгдөхгүй, зарим сумд тайлант онд зээл олгоогүй, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлээгүй зэрэг нөлөөлж байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/					
д.д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувь
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	3,933.5	3,605.7	327.8	91.7%
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	19,300.9	18,417.4	883.5	95.4 %
3	Мэргэжлийн хяналт	265.5	263.0	2.5	99.1 %
4	Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	300.4	293.3	7.1	97.6 %
5	Орон нутгийн зорилтод хөрөнгө оруулалт	24,396.4	21,206.6	3,189.8	86.9%
6	Мал аж ахуйг хөгжүүлэх	506.9	506.8	0.1	100%
7	Авто тээврийн хяналт, зохицуулалт, үйлчилгээ нийтийн тээвэр	12.9	12.9	-	100%
8	Авто зам	651.9	494.4	157.5	75.8 %
9	Ойжуулалт	223.5	215.2	8.3	96.3 %
10	Хүрээлэн буй орчны бодлого удирдлага	1,441.5	1,439.4	2.1	99.9%
11	Хот байгуулалт, тохижилт	1,269.9	1,269.9	-	100%
12	Биеийн тамир спорт	893.4	843.2	50.2	94.4%
13	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	747.5	712.5	35.0	95.3%
14	Соёл урлаг	1,320.3	1,241.7	78.6	94%
15	Сургуулийн өмнөх боловсрол	1,644.9	1,589.3	55.6	96.6%

16	Ерөнхий боловсрол	6,286.7	6,113.1	173.6	97.2%
17	Мэргэжлийн боловсрол	678.2	676.8	1.4	99.8%
18	Нийгмийн халамж	115.6	115.6	-	100%
19	Ахмад настны хөгжил хамгаалал	106.4	106.4	-	100%
20	Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид	3,033.8	1,626.7	1,407.1	53.6%
21	Гүйцэтгэх засаглалын удирдлага	568.7	-	568.7	-
<b>Дүн</b>		<b>67,698.9</b>	<b>60,749.9</b>	<b>6,949.0</b>	<b>89.7%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Цаашид орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын гүйцэтгэлийг хангаж ажиллах, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг бодитой төлөвлөж, тухайн оны төсвийг баталж байх шаардлагатай байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтээр дээд шатны төсөв захирагчаас 8 байгууллага 267.4 сая төгрөгийн, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 48 байгууллага 6,143.1 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үүнээс цалин, нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж, бараа материал, эд хогшил урсгал засвар, дотоод албан томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардал, нэг удаагийн тэтгэмж урамшуулал зэрэг урсгал зардалд 6,756.7 сая төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 640.5 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтийн дансаар Сангийн сайдын багцаас аймгийн Төрөх эмнэлэг, Дөрвөлжин сумын Засаг даргын Тамгын газар, Отгон сумын Эрүүл мэндийн төвийн засварын санхүүжилт, архивын нийтлэг үйлчилгээний алба хаагчдын цалин, АОНХС-аас сумдад эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний санхүүжилт, төсөвт байгууллагуудын өөрийн орлого зэрэг байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

ТЕЗ нь аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд "Чадварлаг эмч", "Чадварлаг багш", "Хөдөлгөөн эрүүл мэнд", "Тогтвортой амьдрал-амгалан гэр бүл", "Даян мэргэн", "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III", "Төрийн үйлчилгээг багт", "Аз жаргалтай ажлын байр" зэрэг арга хэмжээнүүдийг тусган, үе шаттай хэрэгжүүлж байна. Мөн НҮБ-ийн ADAPT, ENSURE төсөл, Японы Өвсний үндэс, Хүүхдийг ивээх сан, Дэлхийн зөн, Солонгосын дулааны станц, Польшийн цэвэрлэх байгууламжийн төсөл болон Азийн хөгжлийн банкны усалгаатай газар тариалан хөгжүүлэх төсөл хэрэгжиж байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар

илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Завхан аймгийн Засаг дарга нь 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 1/285 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгө 67,482.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 1,012.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 759.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2022 оны А/59 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”, А/89 дүгээр тушаалаар баталсан “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ын хэрэгжилтийг төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын хүрээнд үзэхэд Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн 94.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс 29.2 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж, 13.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 51.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн:

- 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтыг зөрчин цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авсан;
- 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.3, 12.1.4 дахь заалтуудыг зөрчин албан хаагчдын гар утасны төлбөр, хэвлэл захиалгын төлбөр, нутгийн зөвлөлийн уулзалт, золголтын арга хэмжээ зэрэг хуулиар зөвшөөрөөгүй бусад зардалд гаргасан;
- 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтыг зөрчин цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авалт хийсэн;
- 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.4, 15.1.5, 15.1.7 дахь заалтуудыг зөрчин хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгосон, Засаг даргын нөөц хөрөнгөөс телевизийн нэвтрүүлэг, сурталчилгаа, бэлэг дурсгалын зүйл худалдан авсан, чихэр, жимс зэрэгт зарцуулсан;
- 15 дугаар зүйлийн 15.2.3 дахь заалтыг зөрчин албан хаагчдыг чадавхжуулах сургалтын цахим хэлбэрт шилжүүлээгүй улмаас сургалтын төлбөр, автобус унааны зардал гаргасан зөрчлүүд байна.

Аудит хийсэн хэлбэр	Акт		Албан шаардлага		Зөвлөмж		Нийт тоо	Нийт мөнгөн
	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн		
Дүгнэлт гаргасан	6	13.8	10	45.6	3	19.3	19	78.7
Түүвэрт хамруулсан	1	0.1	3	6.2	3	9.9	7	16.2
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>13.9</b>	<b>13</b>	<b>51.8</b>	<b>6</b>	<b>29.2</b>	<b>26</b>	<b>94.9</b>

Төрийн хэмнэлтийн бодлогыг төрийн аудиттай уялдуулах замаар аудитын явцад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах аар нийт 73 эрсдэлээс тухайн байгууллагуудад хамаарал бүхий эрсдэлүүдийг сонгож, төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг шалгасан.

Мөн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан автомашины хязгаарлалтын хэрэгжилтийг шалгахад 2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 4 дүгээр тэмдэглэлд орон нутгийн өмчит байгууллагаас татан төвлөрүүлсэн автомашиныг цаашид зайлшгүй шаардлагатай байгаа орон нутгийн өмчит хуулийн этгээдэд шилжүүлэх, худалдах, актлах ажлыг зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт мэдэгдэл хүргүүлсэн байна. Үүнтэй холбоотой ОНӨГ нь аймгийн хэмжээнд 49 автомашин татан төвлөрүүлэхээс аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагаас 14 автомашин, сумдын ЗДТГ-аас 14 автомашин нийт 28 автомашиныг битүүмжилсэн байна. Үүнээс 6 автомашиныг дуудлага худалдаагаар оруулж, 31.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоолын дагуу Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор төрийн өмчит хуулийн этгээдээс татан төвлөрүүлсэн Фургон автомашиныг Эрүүл мэндийн газар, Түдэвтэй, Сонгино, Тэлмэн сумдын Эрүүл мэндийн төвд, суудлын автомашиныг Баянтэс, Дөрвөлжин, Завханмандал, Цагаанчулуут сумдын ЗДТГ, аймгийн ИТХ зэрэгт тус тус шилжүүлэн өгч, баланст тусган ашиглалтын гэрээ байгуулан ажиллаж байна. Дээрх ажлыг хэрэгжүүлснээр байгууллагуудын автомашины ашиглалтад ахиц гарах, шатахууны зардал хэмнэх, илүүдэлтэй ашиглалтгүй хөрөнгийг худалдсаны дүнд төсөвт тодорхой хэмжээний орлого орсон зэрэг нь урьд оноос тодорхой ахиц, үр нөлөө гарсан байна.

ТЕЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар Засаг даргын нөөц хөрөнгийг Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж, арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй, үрэлгэн зарцуулсан 217.5 сая төгрөгийн болон цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогоос хоол, бэлэг дурсгалын зардалд үрэлгэн зарцуулсан 4.6 сая төгрөгийн, нийт 222.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд:**

Үндэсний аудитын газраас ирүүлсэн 2024 оны 03 сарын 22-ны өдрийн 07/768 дугаар албан бичгийн дагуу орон нутгийн тусгай сангийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг хянан үзэхэд аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн сан болон Хоршоо хөгжүүлэх сангаас жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгосон эргэн төлөх нөхцөлгүй дэмжлэг үзүүлсэн зөрчил илрээгүй байна.

Мөн Аудитын нэгдсэн удирдлагын газраас ирүүлсэн чиглэлийн дагуу төсвийн шууд захирагчийн санхүүгийн аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд Улиастай сумын ИТХ-ын төлөөлөгчид болон ЗДТГ-ын албан хаагчдыг, Завханмандал сумын ИТХ-ын

төлөөлөгчид, Дөрвөлжин сумын ЗДТГ-ын албан хаагчдыг тус тус туршлага судлуулах, сургалтад хамруулах нэрээр БНХАУ-д аялуулж, төсвөөс 51.1 сая төгрөгийг зарцуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна. Гадаад орнуудад сургалт, аяллын зорилгоор зорчсон өөр зөрчил гараагүй байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Аймгийн Засаг даргын үйл ажиллагаанд завсрын аудит хийгдээгүй байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Сумдад эрх шилжүүлэн олгож буй хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний санхүүжилтийг ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтээр олгож байгаа нь худалдан авах ажиллагааны аргыг буруу сонгох, тендер сонгон шалгаруулалтаас зайлсхийх нөхцөлийг бүрдүүлсэн, Аймгийн ОНХС-ийн дансыг үлдэгдэлтэй тайлагнаж байхад барьцаа хөрөнгийн данс руу хөрөнгө шилжүүлсэн, Сонгуулийн үр дүнгээр ажлаасаа чөлөөлөгдөөгүй алба хаагчдад тэтгэмж олгосон, Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар төсвийн зарлагыг бодитой төлөвлөж, батлаагүй, эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр төсөвт зохицуулалт хийсэн, татварын орлогын гүйцэтгэлийг Татварын хэлтсийн мэдээнээс зөрүүтэй тайлагнасан, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зэрэг нийт 3,528.2 сая төгрөгийн зөрчилд 6 заалт зөвлөмж, Орон нутгийн хөрөнгө оруулалтад тавих хяналтыг хэрэгжүүлээгүй, техник хяналтын зардлын анхан шатны баримтын бүрдүүлэлтийг хангаж ажиллаагүй, Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогын зарцуулалт анхан шатны баримтгүй, эрх бүхий албан хаагчийн шийдвэргүй зарцуулсан, Хүү торгуулийн орлогоос цагдаагийн алба хаагчдын торгуулийн тоног төхөөрөмжийн төлбөр, дата төлбөр төлсөн, багаж төхөөрөмж худалдан авсан болон аймгийн ИТХ-аар баталсан төсвийн тодотголоор сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлэн баталсан санхүүжилтийг дутуу олгосон, хөрөнгө оруулалтаар хийх төсөл, арга хэмжээний зураг төсвийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар тендер зарлаагүй зэрэг нийт 4,503.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, Сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг батлагдсан төсвөөс илүү олгосон болон өмнөх аудитаар он дамжсан 5.0 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй нийт 75.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна. Мөн өмнөх оны төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар албан үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн Алдархаан, Завханмандал, Дөрвөлжин, Их-Уул, Сантмаргаз, Сонгино, Тосонцэнгэл, Түдэвтэй, Тэс, Ургамал, Яруу сумдын Засаг дарга нарт сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлсэн байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Илрүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	75.1	2	75.1	100%
Албан шаардлага	6	4,503.0	6	4,262.4	95.3%
Зөвлөмж	6	3,528.2	5	3,065.1	86.8%
Сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага	11	-	3	-	27.3%
<b>Нийт дүн</b>	<b>25</b>	<b>8,106.3</b>	<b>16</b>	<b>7,402.6</b>	<b>64%</b>

Хөрөнгө оруулалтаар хийх төсөл, арга хэмжээний зураг төсвийн 87.8 сая төгрөгийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар тендер зарлаж, худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ. Мөн өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар аймгийн Засаг даргад 11 сумын Засаг даргад сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлснээс 3 албан шаардлагыг хэрэгжүүлж, 8 албан шаардлагыг одоог

хүртэл хэрэгжүүлээгүй тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу аймгийн Засаг даргад сахилгын хариуцлага тооцуулах саналыг Монгол Улсын Ерөнхий аудиторт хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн шууд захирагчдын алдаа зөрчилд дүн шинжилгээ хийхэд Улсын баяр наадмын зардлыг Засгийн газрын тогтоолоос илүү зарцуулсан зөрчил нийтлэг гарсан байна. Улсын баяр наадмын зардлыг Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоолоор аймагт 10 сая төгрөг, суманд 5 сая төгрөг байхаар тогтоосон бөгөөд баяр наадмын зардал хүрэлцдэггүйгээс хэтрүүлэн зарцуулах нөхцөл байдал үүсэж байгааг анхаарч, зардлын хэмжээг нэмэгдүүлэх талаар дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн 110.4 сая төгрөгийн алдааг аудитын явцад залрууллаа.

**Залруулсан алдаа:** Ахмадын хороонд олгосон 106.4 сая төгрөгийн санхүүжилтийг хоорондын тооцоо нийлж, устгал хийгээгүй, төсөвт байгууллагад олгосон 4.0 сая төгрөгийн санхүүжилтийг бараа үйлчилгээний бусад зардлаар тайлагнасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д "Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан тодруулга бэлтгэх журам"-тай нийцэхгүй, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,208.0 сая төгрөгийн зөрчил илэрч, 4.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 684.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 519.1 сая төгрөгийн зөрчилд 6 заалт зөвлөмж, хөрөнгийн бүртгэл, ашиглалттай холбоотой зөрчилд аймгийн Орон нутгийн өмчийн газарт 1 заалт зөвлөмж хүргүүлээ.

**Зөрчил:** Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,208.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс 4.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 87.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 519.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөхөөр шийдвэрлэж, төсвийн шууд захирагчдын аудитаар илэрсэн 596.3 сая төгрөгийн зөрчлийг шинж чанарын хувьд материаллаг гэж үзлээ.

Аудитаар нийт илрүүлсэн 1,208.0 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс 195.8 сая төгрөгөөр давсан тул **"Хязгаарлалттай"** дүгнэлт өглөө.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 24 сумын төсвийн төвлөрүүлэн захирагч, 105 төсвийн байгууллага, 5 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж нийт 134 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна. Аудитад хамрагдсан 134 санхүүгийн тайлангаас төсөв, санхүүжилт, хамрах хүрээ, аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд үзүүлэх нөлөө харьцангуй багатай 86 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 48 санхүүгийн тайланд бие даасан дүгнэлт гаргалаа. Үүнд:

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр		Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан				

A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Төсвийн шууд захирагч	105	19	86		10	6	2	1
2	Төсвийн төвлөрүүлэн захирагч	24	24			19	5		
3	ОНӨААН	5	5			4	1		
	<b>НИЙТ</b>	<b>134</b>	<b>48</b>	<b>86</b>		<b>33</b>	<b>12</b>	<b>2</b>	<b>1</b>

**Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит:**

Аудитаар нийт 11,366.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 2,589.7 сая төгрөгийн алдааг залруулж, 2,762.5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж, 5,806.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, 159.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 48.3 сая төгрөгийн зөрчлийг хуулийн байгууллагад шилжүүлсэн. Аудитаар “Сөрөг” дүгнэлт авсан 2 албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлагыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн.

*Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэлийг аудитын тайлангийн хавсралтаар хүргүүлэв.*

**5.1 Төлбөрийн акт**

Албан ажлаасаа чөлөөлөгдөөгүй Эрдэнэхайрхан сумын Засаг даргын орлогчид ээлжит сонгуулийн дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын дарга болон бүх шатны Засаг дарга нарт олгох нэг удаагийн тэтгэмжийг олгосон 4.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

**5.2 Албан шаардлага**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын алдаа, зөрчлийг нэгтгэн дүгнэхэд сумдад эрх шилжүүлсэн болон аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй, хөрөнгө оруулалтын хүрээнд бий болсон үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй 498.5 сая төгрөгийн, техник хяналтын зардлыг зориулалт бусаар үрэлгэн зарцуулсан 97.8 сая төгрөгийн зөрчил давтагдан гарсанд албан шаардлага хүргүүлээ.

Мөн хөрөнгө оруулалтын 87.8 сая төгрөгийн зураг төсвийн ажилд тендер зарлаж, худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй бөгөөд өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар албан үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн Завханмандал, Их-Уул, Сантмаргаз, Сонгино, Тосонцэнгэл, Түдэвтэй, Ургамал, Яруу сумдын Засаг дарга нарт сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй тул аймгийн Засаг даргад сахилгын хариуцлага тооцуулах саналыг Монгол Улсын Ерөнхий аудиторт хүргүүлээ.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Засаг даргын нөөц хөрөнгөөс 279.6 сая төгрөгийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй, үрэлгэн зарцуулж, анхан шатны баримтын бүрдэл хангаагүй, тус сангийн хөрөнгөөс 131.3 сая төгрөгөөр хөрөнгө оруулалтын шинжтэй зардлыг санхүүжүүлсэн зэрэг зөрчлүүд байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 14 дүгээр зүйлийн 14.2.2-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох”, 14.2.3-т “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.4-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв хуваарилах, зарцуулахтай холбогдсон бүрэн эрхээ төсвийн төвлөрүүлэн захирагч, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх

үндэслэл болохгүй”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.3-д “хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх”, 4.2.6-д “үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх”, 12 дугаар зүйлийн 12.1.4-д “хуулиар зөвшөөрөөгүй бусад”, 15 дугаар зүйлийн 15.1.3-д “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасан, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-тай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, анхан шатны баримтыг хангалттай, зохистой бүрдүүлэх, сангийн хөрөнгөөс хөрөнгө оруулалтын шинж чанартай зардлыг санхүүжүүлэхгүй байх;

## **2. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Барьцаа хөрөнгийн дансанд 2018 онд үүссэн 41.5 сая төгрөгийн, Засаг даргын нөөц хөрөнгө дансанд 2016 онд үүссэн 2.6 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Он дамжсан 44.1 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах;

## **3. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлого, зардлыг нягтлан бодох бүртгэлд тусгалгүй, 37.5 сая төгрөгийн ажил гүйлгээг нэр данс зөрүү гэсэн ангиллаар хийсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д “Төрийн сан дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 37.1.7-д “төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу холбогдох дансанд бүртгэх, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ” 14.4.1-д “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.5-д “бүх орлого”, 14.4.6-д “бүх зардал” гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, толилуулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Цэргийн дүйцүүлэх мөнгөн төлбөрийн орлогоос зарцуулах зардлыг аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгаж, зардлын эдийн засгийн ангилалд төлөвлөж зарцуулах;

## **4. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогоос 4.6 сая төгрөгийг хоол, бэлэг дурсгалын зардалд үр ашиггүй, үрэлгэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 14 дүгээр зүйлийн 14.2.3-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д “хуулиар зөвшөөрөөгүй бусад”, 15 дугаар зүйлийн 15.1.5-д “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогыг журмын дагуу үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах;

**5. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Цэргийн штабын бэлэн байдал, мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгоор худалдаж авсан 3.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг данс бүртгэлд тусгаж, эзэмшүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д “Төрийн сан дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 37.1.7-д “төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу холбогдох дансанд бүртгэх, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ” 14.4.2-д “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, толилуулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Цэргийн штабын бэлэн байдал, мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгоор худалдаж авсан тоног төхөөрөмжүүдийг данс бүртгэлд тусгаж, эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлээр эзэмшүүлэх;

**6. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогын дансанд орон нутгийн хөрөнгө оруулалтаас 19.0 сая төгрөгийг төвлөрүүлж, нэр данс зөрүү гэсэн ангиллаар зарцуулж, нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7-д “төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу холбогдох дансанд бүртгэх, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ” 14.4.2-д “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, толилуулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогын дансанд өөр эх үүсвэрээс хөрөнгө төвлөрүүлж зарцуулахгүй байх;

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Зөрчлийн утга	/сая. төгрөгөөр/									
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн
Ахмадын хороонд олгосон 106.4 сая төгрөгийн санхүүжилтийг хоорондын тоцоо нийлж, устгал хийгээгүй	1	106.4			1	106.4	1	106.4		
Төсөвт байгууллагад олгосон санхүүжилт 4.0 сая төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаар тайлагнасан	1	4.0			1	4.0	1	4.0		
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>110.4</b>			<b>2</b>	<b>110.4</b>	<b>2</b>	<b>110.4</b>		

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Зөрчлийн утга	/сая. төгрөгөөр/											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өмнөх оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитаар Завханмандал, Их-Уул, Сантмаргаз, Сонгино, Тосонцэнгэл, Түдэвтэй, Ургамал, Яруу сумдын Засаг дарга нарт сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлсэн боловч шийдвэрийг хэрэгжүүлж ажиллаагүй, байна. Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалтыг зөрчиж байна.	1								1	1		
Засаг даргын нөөц хөрөнгийг Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж, арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй, үрэлгэн зарцуулж, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй. Тус сангийн хөрөнгөөс хөрөнгө оруулалтын шинжтэй зардал санхүүжүүлсэн.	1	410.9						1	410.9			
Өмнөх оны аудитаар хөрөнгө оруулалтын ажлын зураг төсвийн тендер зарлаагүй зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.	1	87.8	1	87.8								

Завхан аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит

Техник хяналтын зардлыг зориулалт бусаар урэлгэн зарцуулсан	1	97.8		1	97.8				
Сумдад эрх шилжүүлсэн болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээний гүйцэтгэлд нь хяналт тавьдаггүй зөрчил жил бүр давтагдаж байна.	1	498.5		1	498.5				
Хөрөнгө оруулалтын хүрээнд бий болсон үндсэн хөрөнгийн талаарх мэдээллийг Орон нутгийн өмчийн газарт мэдээлж хамтран ажилладаггүй, хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг данс бүртгэлд тусгадаггүй зөрчил жил бүр давтагдаж байна.	1	-		1	-				
Өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн аймгийн Засаг даргын орлогч, ажлаас чөлөөлөгдөөгүй Эрдэнэхайрхан сумын Засаг даргын орлогч нарт сонгуулийн үр дүнд чөлөөлөгдсөн улс төрийн албан хаагчдад олгох нэг удаагийн тэтгэмжийг олгосон	1	4.8	1	4.8					
Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогыг хоол, бэлэг дурсгалын зардалд үр ашиггүй, урэлгэн зарцуулсан	1	4.6				1	4.6		
Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогоос Цэргийн штабын бэлэн байдал, мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгоор худалдаж авсан тоног төхөөрөмжүүдийг данс бүртгэлд тусгаж, эзэмшүүлээгүй	1	3.0				1	3.0		
Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогын дансанд орон нутгийн хөрөнгө оруулалтаас 19.0 сая төгрөгийг төвлөрүүлж, нэр данс зөрүү гэсэн ангиллаар зарцуулж, нягтлан бодох бүртгэлд тусгаагүй	1	19.0				1	19.0		
Барьцаа хөрөнгийн дансанд 2018 онд үүссэн 41.5 сая төгрөгийн, аймгийн Засаг дарга дансанд 2016 онд үүссэн 2.6 сая төгрөгийн өглөгийг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй	1	44.1				1	44.1		
Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогыг зарцуулахдаа зардлыг нэр данс зөрүүгээр гаргаж, мөнгөн төлбөрийн орлогыг төлөвлөж зарцуулахгүйгээс санхүүгийн тайланд орлого, зардал тусгагдахгүй байна.	1	37.5				1	37.5		
Үлдэх өртөггүй хөрөнгийн бүртгэлийг цэгцлэх, дахин үнэлгээ хийх шалгуур хангасан хөрөнгөнд үнэлгээ хийж бүртгэлд тусгах болон цаашид ашиглах боломжгүй хөрөнүүдийг холбогдох газрын зөвшөөрлийн дагуу данснаас хасах арга	1					1			

